



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 онь 08 сарын 20 өдөр

Дугаар А/526

Номгон


「Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны
өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах
тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а" дахь заалт, "Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах" тухай Засгийн газрын 221 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын хэсгийг нэгдүгээр, Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нарийвчилсан төлөвлөгөөг хоёрдугаар, аймаг, сумдад зайлшгүй бэлтгэх өвс, тэжээлийн аюулгүй нөөцийн хэмжээг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нарийвчилсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж 10 дугаар сарын 25-ны дотор тайлагнахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Баттөр), Мал эмнэлгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Хишигбаатар)-д үүрэг болгосугай.




ДАРГА

Д. МӨНХСАЙХАН

601210215

Аймгийн Засаг даргын 2021 он 10 дугаар
сарын 20-ны өдрийн А/526 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт



**ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН 2021-2022 ОНЫ
ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГУУЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч Б.Батсуурь – Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга: Ж.Баттөр – Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга
Гишүүд: Т.Хишигбаатар – Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Т.Саранчимэг – Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн
хэлтсийн Хөдөө аж ахуй хариуцсан ахлах мэргэжилтэн
Б.Биндэръяа- Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн
хэлтсийн Хүнс, худалдаа, жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн
Н.Уртнасан- Сум дундын ойн ангийн дарга
Л.Оюун-Эрдэнэ – Мал эмнэлгийн газрын дарга
С.Тэгшбаяр – Хүнс хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн албаны дарга
Сумдын Засаг дарга нар

_____оОо_____

Аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 20-ны
 өдрийн А/526 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт




**БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН 2021-2022 ОНЫ
 ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ НАРИЙВЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх ажил арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага
1	2	3	4
1	Засгийн газрын 2021 оны 221 дүгээр тогтоол, Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нарийвчилсан төлөвлөгөөний дагуу сумдуудад төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах	VIII/25-ны дотор	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, сумдын Засаг дарга нар
2	Аймгийн хэмжээнд 2021-2022 онд өвөлжих болон хэрэгцээлэх малын тоог малын төрөл, сүргийн зохистой харьцаанд тохируулан сум бүрээр нэгтгэн гаргаж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр эдийн засгийн эргэлтэд оруулах малын тоог тодорхойлж экспортлох төлөвлөгөө, хуваарь гарган хүнсний болон хөнгөн үйлдвэрүүдтэй холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хамтран ажиллах	IX/20-ны дотор	Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын Засаг дарга нар
3	Аймгийн хүн амын өвөл, хаврын улиралын хүнсний хэрэгцээнд зориулан шаардлагатай махны нөөц бүрдүүлэлтийг хийх бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулах	X/20-ны дотор	Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын Засаг дарга нар
4	Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн богино болон дунд хугацааны урьдчилсан мэдээ, цаг агаарын улирлын урьдчилсан төлөв байдлын талаарх мэдээ, мэдээллээр иргэд, малчдыг тогтмол хангах, өвөл хаврын улирлын бэлчээрийн даацыг бодитой тогтоон өвөлжилт, хаваржилтын зураглал гарган хариу арга хэмжээг авч ажиллах	VIII/25- X/20-ны дотор	Ус, цаг уур орчны шинжилгээний төв, Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын Засаг дарга нар
5	Ургац хураалтад ажиллах хүн хүч, техникийн бэлэн байдлыг хангах, цаг агаарын гамшигт үзэгдлээс ургацаа хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	VIII/25- X/20-ны дотор	Ус, цаг уур орчны шинжилгээний төв, Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын Засаг дарга нар
6	Ургац хураах, тээвэрлэх үеийн зам, гүүрийн эвдрэл гэмтлийг шалган тогтоож шаардлагатай засварыг цаг алдалгүй гүйцэтгэх, цаг уурын хүндрэлтэй байдал	IX/20-ны дотор	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Авто тээврийн төв, сумдын

1	2	3	4
	үүсэхээс өмнө техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, замын арчлалт завсарын ажлыг дуусгах		Засаг дарга нар
7	Коронавируст цар тахлын үед хадлан тэжээл бэлтгэл, ургац хураалтын ажилд оролцож байгаа аж ахуй нэгж, иргэдэд халдвар хамгааллын урьдчилан сэргийлэх горим дэглэмийг чанд мөрдүүлэн ажиллах	IX/20 хүртэл	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар, сумдын Засаг дарга нар
8	Ургац хураалт, хадлан тэжээл болон мал, мах бэлтгэлийн үед төв зам дагуу хяналтын пост тогтмол ажиллуулж, дамжуулан өнгөрүүлэн хяналт шалгалтыг шуурхай зохион байгуулах арга хэмжээ авах	Байнга	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Цагдаагийн газар
9	Аймаг, сумын хэмжээнд орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээрийг тогтоож, хил заагийг тодорхойлон ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, аймаг дундын отрын бүс нутаг, хилийн зурвас газар, улсын тусгай хамгаалалттай газруудад отроор өвөлжих, хаваржих айл өрх, малын урьдчилсан судалгааг гаргаж зөвшөөрлийг холбогдох байгууллагаас авах	Х/20-ны дотор	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, сумдын Засаг дарга нар
10	Өвөлжөө, хаваржааны болон отрын нөөц бэлчээрийг тодорхой хувиар тогтоон малын хөлөөс чөлөөлөх	Х/20-ны дотор	Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын Засаг дарга нар
11	Хадлангийн талбайг оновчтой хуваарилах, зохистой ашиглах, малчин, мал бүхий иргэдээр байгалийн хадлан, гар тэжээл бэлтгэх ажлыг технологит хугацаанд чанартай гүйцэтгүүлэх, өвс, тэжээл, мал аж ахуйн салбарын материаллаг баазын хангамжийг сайжруулах	Х/20-ны дотор	Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын Засаг дарга нар
12	Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн малын хорио цээрийн дэглэмийг баримтлан бог малын тохироогоор дутагдаж байгаа хээлтүүлэгчийг нөхөн бүрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж, малын чанар сайжруулахад анхаарах, малын үржлийн ажил үйлчилгээг технологийн хугацаанд чанартай зохион байгуулах	Х/20-ны дотор	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, сумдын Засаг дарга нар
13	Малчдыг малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах, гурил тэжээлийн үйлдвэрүүдтэй харилцан бараа бүтээгдэхүүн солилцох (бартер), малаа зарж борлуулахад нь арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах	Х/20-ны дотор	Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын Засаг дарга нар
14	Үндэсний боловсруулах үйлдвэрт нийлүүлэх арьс шир, ноолуурын түүхий эдийг бэлтгэх, тээвэрлэх ажлын төлөвлөгөө, хуваарь гарган хэрэгжилтийг хангаж ажиллах	Байнга	Хүнс, хөдөө аж ахуйн газар
15	Отроор нүүдэллэж байгаа малчин өрхийг тухайн нутгийн захиргааны байгууллага болон хүн, мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлэх, холбогдох мэргэжлийн байгууллагын тусламж үйлчилгээг үзүүлж ажиллах	Байнга	Хүнс, хөдөө аж ахуйн газар

1	2	3	4
16	Худаг, уст цэг шинээр гаргах болон бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг чанартай, үр дүнтэй зохион байгуулж ажиллах	X/20-ны дотор	Хүнс, хөдөө аж ахуйн газар
17	Аймаг, сумын нөөцөд зайлшгүй бэлтгэх шаардлагатай өвс, тэжээлийг уг захирамжийн гуравдугаар хавсралтад заасны дагуу бүрдүүлэн байршуулж, өвөлжилт хаваржилтын бэлэн байдлыг хангаж ажиллах	X/20-ны дотор	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Сум дундын ойн анги, сумдын Засаг дарга нар
18	2020-2021 онд аймгийн аюулгүйн нөөцөд бэлтгэсэн өвс, тэжээлийн тооцоог яаралтай дуусган 2021-2022 онд аймгийн аюулгүйн нөөцийн бүрдүүлэлтэд онцгой анхаарч ажиллах	X/20-ны дотор	Сум дундын ойн анги, сумдын Засаг дарга нар
19	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд чанартай зохион байгуулж мал эмнэлгийн үйлчилгээний бэлэн байдал, шуурхай удирдлагаар хангаж ажиллах	X/20-ны дотор	Мал эмнэлгийн газар
20	Малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулж, холбогдох хууль тогтоомжийг малчид, иргэдэд сурталчлах, мэдээлэл арга зүйгээр хангаж ажиллах	Байнга	Мал эмнэлгийн газар, сумдын Засаг дарга нар
21	Хөдөө аж ахуйн салбарт улс, аймаг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын үр дүнд анхаарч гүйцэтгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, холбогдох арга хэмжээг авч ажиллах (Услалтын системийн засвар, худаг уст цэг шинээр гаргах, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх, Мал эмнэлгийн салбарын хөрөнгө оруулалт, Хөдөө аж ахуйн салбарын кластерийн хөрөнгө оруулалт гэх мэт)	X/01-ний дотор	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар
22	Сум, байгууллага, аж ахуй нэгжийн хамтын ажиллагаа, харилцан туслах үйл ажиллагааг үргэлжлүүлэх (шефийн холбоо)	Байнга	Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын Засаг дарга нар
23	Зам, давааг өвөл хаврын улиралд байнгын нээлттэй байлгах, хүн хүч, техникийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах	Байнга	Онцгой байдлын газар, Авто тээврийн төв, сумдын Засаг дарга нар
24	Энэхүү төлөвлөгөөний биелэлтийг холбогдох хэлтэс, агентлаг, сумдаас авч нэгтгэн 2021 оны 10 дугаар сарын 25-ны дотор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, аймгийн Засаг дарга, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст тайлагнах	X/25-ны дотор	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар

Аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар
сарын 20-ны өдрийн А/526 дугаар захирамжийн
3 дугаар хавсралт



**АЙМАГ, СУМДАД БЭЛТГЭХ ӨВС ТЭЖЭЭЛИЙН
АЮУЛГҮЙ НӨӨЦИЙН ХЭМЖЭЭ**

№	Сумын нэр	Өвс тэжээл бэлтгэх төлөвлөгөө	
		Өвс /тн/	Тэжээл /тн/
1	Баянхонгор	100	50
2	Баацагаан	100	50
3	Баянбулаг	100	50
4	Баянговь	100	50
5	Баянлиг	100	50
6	Баян-Овоо	100	50
7	Баян-Өндөр	100	50
8	Баянцагаан	100	50
9	Богд	100	50
10	Бөмбөгөр	100	50
11	Бууцагаан	100	50
12	Галуут	100	50
13	Гурванбулаг	100	50
14	Жаргалант	100	50
15	Жинст	100	50
16	Заг	100	50
17	Өлзийт	100	50
18	Хүрээмарал	100	50
19	Шинэжинст	100	50
20	Эрдэнэцогт	100	50
	Аймгийн төвд	300	100
	Нийт дүн	2300	1100

_____оОо_____